



ТӨСӨВ =

МӨНГӨ =

ХҮНИЙ ЭРХ

“Улсын төсөв бол улс орны нэг үнэт зүйл юм. Хэрэв төсөв нь хүний эрхийн төлөө биш бол түүнийг үнэт зүйл хэмээн нэрийдэхэд хэцүү”.

Профессор Аоиф Нолан, 2014

ТАНЫ ЗАЙЛШГҮЙ МЭДЭЖ БАЙХ ЁСТОЙ
ХҮНИЙ ЭРХИЙН НЭР ТОМЬЁО

УЛСЫН ТӨСӨВ ГЭЖ ЮУ ВЭ?

Монгол Улсын Төсвийн тухай хуульд зааснаар “төсөв” гэж төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогцыг хэлнэ.

Иймээс улсын төсөв гэдэг нь засгийн газрын хөрөнгө оруулалт хийх төлөвлөгөө гэж хэлж болох бөгөөд эдийн засгийг удирдах хамгийн чухал арга хэрэгсэл юм. Улсын төсөв гэдэгт:

- төрийн мэдэлд төвлөрүүлсэн хөрөнгө (орлого)
- мөнгөө хэнээс эсвэл хаанаас төвлөрүүлэх (эх үүсвэр)
- мөнгөө хэрхэн хуваарилах (хуваарилалт)
- мөнгөө хэрхэн зарцуулах (зардал) зэрэг багтана.

ХҮНИЙ ЭРХЭД СУУРИЛСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Улс орнууд хүний эрхийн үүрэг хариуцлагаа биелүүлж, олон улсын гэрээний зүйл заалтыг дагаж байгаа эсэхийг шалгах арга хэрэгслийг хэлнэ.

Хүний эрхэд суурилсан гурван төрлийн шалгуур үзүүлэлт байдаг нь бүтцийн, нөөцийн, үр дүнгийн үзүүлэлтүүд юм. Эдгээрийг ашиглан хүний эрхийг хангахтай холбоотой санал санаачилга, хүч хөдөлмөр болон үр дүнг дүгнэх боломжтой.

- **Бүтцийн үзүүлэлт:** Энэ нь олон улсаар хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн хэм хэмжээг дагаж мөрдөхийн тулд тухайн улсын гаргасан **санаачилгыг** дүгнэдэг.
- **Нөөцийн үзүүлэлт:** Энэ нь тухайн улс хүний эрхийн үүрэг хариуцлагаа биелүүлэхийн тулд гаргасан **хүч хөдөлмөрийг** дүгнэдэг.
- **Үр дүнгийн үзүүлэлт:** хүний эрхийн дүрэм журам хэрхэн хэрэгжиж, ямар үр дүн гаргасныг хэмжиж, улс орны **гүйцэтгэлийг** дүгнэдэг.

БОЛОМЖИТ БҮХ НӨӨЦ

Улсын төсвийн боломжит хамгийн их хувийг хүний эрхийг хангахад зарцуулахыг хэлнэ. Үүнд дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- байгаа нөөцийг алагчлалгүйгээр зарцуулах
- нэмэлт нөөцийг зөв, шударгаар бүрдүүлэх
- санхүүгийн нөөцөөс гадна хөрөнгийн, байгалийн, технологийн гэх мэт нөөцүүд орно.

ХҮРЭЛЦЭЭТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН, ЧАНАРТАЙ - ХХХЧ

“Хүрэлцээтэй, Хүртээмжтэй, Хүлээн зөвшөөрөгдсөн, Чанартай” гэсэн үгнүүдийн товчлол. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтийг үнэлэхийн тулд ашигладаг суурь хэм хэмжээ.

- **Хүрэлцээтэй:** Шаардлагатай бүтээгдэхүүн үйлчилгээ, түүний дэд бүтэц нь хангалттай хэмжээтэй байх
- **Хүртээмжтэй:** Бие махбодын болон эдийн засгийн хувьд ялгаварлан гадуурхалгүй хүртээмжтэй байх, олон нийт мэдээлэлтэй байх
- **Хүлээн зөвшөөрөгдсөн:** Тухайн газар орны хувьд соёлын болон нийгмийн талаас хүлээн зөвшөөрөгдсөн байх
- **Чанартай:** Стандарт хангасан, аюулгүй байх

НААД ЗАХЫН ТҮВШИН

Улс орны эдийн засаг ямар ч түвшинд байсан гэсэн иргэдийнхээ эрхийг “наад захын түвшинд” хангах үүрэгтэй. Хүний эрх наад захын түвшинд хангагдсанаар **амьжиргааны зохих түвшинд амьдрах эрх баталгаажих** бөгөөд энэ нь эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын үйлчилгээ авах, хөдөлмөрлөх, орон байраар хангагдах эрхүүдтэй нягт уялдаатай байдаг. Ингэснээр хүн бүр нэр төртэй амьдрах баталгаатай болж чадна. Хэрэв засгийн газар ард иргэдийнхээ эрхийг наад захын түвшинд хэрэгжүүлж чадахгүй бол Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын Пактаар хүлээн зөвшөөрсөн үүргээ биелүүлж чадахгүй байна гэсэн үг. Түүнчлэн улс орнууд нь нөөц бололцооныхоо хэрээр, боломжит бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй тохиолдолд дээрх Пактаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж үзнэ.

ҮЛ ЯЛГАВАРЛАЛ

Зайлшгүй шалтгаан буюу **үндэслэлтэй** биш л бол бусдаас ялгаатай хүмүүст өөрөөр хандахгүй байхыг хэлнэ.

АРГА ХЭМЖЭЭ АВАХ ҮҮРЭГ

Засгийн газар хүний эрхийг хангахын тулд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Жишээ нь, ажилгүйдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх гэх мэт.

ҮР ДҮН ГАРГАХ ҮҮРЭГ

Засгийн газар аливаа тавьсан зорилго, зорилтдоо хүрэх үүрэг хариуцлагыг хэлнэ. Жишээ нь, ажилгүйдлийг зорьсон хэмжээндээ хүртэл бууруулах гэх мэт. **Үр дүн нь дэвшилттэй** харин **арга хэмжээ нь нэн даруй** байх шаардлагатай.

АЛХАМ ХИЙХ ҮҮРЭГ

Засгийн газар хүний эрхийн үүрэг, хариуцлагынхаа дагуу шаардлагатай алхам авч хэрэгжүүлэх ёстой. Хэрэгжүүлэх алхмууд нь:

- хуулийн
- шүүхийн
- захиргааны
- санхүүгийн
- боловсролын
- нийгмийн арга хэмжээнүүд байж болно.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧИМ

- Эрх эдлэгчдийн **идэвхтэй оролцоог хангах** бүхий л арга хэмжээ авах
- Авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд нь **ил тод байдал, хариуцлага, үл ялгаварлах зарчимд нийцсэн** байх
- Улс орнууд нь захиргааны болон шүүхийн арга хэрэгслээр **хохирлыг арилгах**.

ЗОХИСТОЙ АРГА ЗАМ

Аливаа нөхцөл байдлыг хүчээр бус зохистой арга замаар шийдэхийг хэлнэ.

ДЭВШИЛТТЭЙ БАЙХ

“Дэвшилттэй байх” үүрэг хариуцлага нь засгийн газрыг эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд боломжийнхоо хэрээр хамгийн үр ашигтай, хурдан ажиллахыг шаарддаг. Зарим тохиолдолд засгийн газрууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг шууд хангах боломжгүй гэдгийг НҮБ хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ засгийн газрууд боломжийнхоо хэрээр дэвшилт гаргахын төлөө ажиллах ёстой.

ЗОХИСТОЙ БАЙХ

Засгийн газрын авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь нөхцөл байдалдаа тохирсон байх ёстой.

УХРАХҮЙ БАЙХ

Засгийн газар нь хүний эрхийг хангахдаа ухрах алхам хийхгүй, байнга урагшлах зарчим баримтална. Хэрэв хүний эрхээс дордуулсан бодлого, шийдвэр баталсан бол тухайн бодлого, шийдвэр нь:

- түр зуурын
- зайлшгүй шаардлагатай, тэгш үйлчилсэн (бусад сонголтууд нь илүү хор уршигтай)
- ялгаварлан гадуурхалгүй, тэгш бус байдал үүсгээгүй
- хүний наад захын эрхийн хэм хэмжээг хөндөөгүй
- санхүүгийн болон бусад бүх боломжийг нэг бүрчлэн харгалзсан байх шаардлагатай.

БОЛОМЖИТ БҮХ НӨӨЦӨӨ АШИГЛАХ

Улс орнууд нөөцийн хуваарилалтаа хэрхэн хийх нь тэдний сонголт боловч хүний эрхийн хэрэгжилт “нэн тэргүүнд” тавигдах ёстой. Ингэж байж “шударга, үр ашигтай” хуваарилалт болно.

Засгийн газраас хүний эрхийг хангахад дан ганц нөөцийн хуваарилалтыг яаж хийснээр тогтохгүй, хангалттай нөөц бүрдүүлэхийн тулд ямар арга хэрэглэсэн нь, тэрхүү арга хэрэгсэл нь шударга, зөв байж чадаж байна уу гэдгийг харгалзан үзнэ. Цаашлаад, хэрэв засгийн газар хөрөнгөө үр ашигтай зарцуулаагүй, үрэлгэн бол боломжит бүх нөөцөө ашигласанд тооцохгүй.

ХҮНИЙ ЭРХИЙГ ХҮНДЭТГЭХ, ХАМГААЛАХ, ХАНГАХ

Энэ бол хүний эрхийг хангахад чиглэсэн Засгийн газрын үүрэг хариуцлага юм.

- Хүний эрхийг хүндэтгэх гэдэг нь засгийн газар хүний эрх зөрчих аливаа үйл ажиллагаа явуулахаас татгалзахыг хэлнэ.
- Хүний эрхийг хамгаалах гэдэг нь засгийн газар гуравдагч этгээдийн зүгээс хүний эрх зөрчих үйл ажиллагаа явуулахаас хамгаалахыг хэлнэ.
- Хүний эрхийг хангах гэдэг нь засгийн газар хүний эрхийг хэрэгжүүлэхийн тулд эерэг арга зам хэрэглэхийг хэлнэ.